



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онгон сумын хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2026/121/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2026 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г.Даваа Утас:70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn Аудитын менежер:М.Нарантуяа Утас:99029193 Цахим хаяг:Narantuyam@audit.gov.mn Ахлах аудитор: Ө.Золзаяа Утас:70512123 Цахим хаяг: Zolzayau@audit.gov.mn Аккурэйт финанс аудит ХХК-ийн захирал:Ж.Оюунбилэг Утас:70133743 Цахим хаяг:acc.fin.audit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075
Утас: (976) 70518396
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2026.02.25 № 99
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ө.ЭНХ-ОРЧЛОН
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онгон сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 4,834.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, сум байгуулагдсаны 100 жилийн ойгоор иргэд, байгууллагаас хандивласан 67,625.0 мянган төгрөгийн хөрөнгийг эрхлэгчийн 2025 оны А/26 дугаар тушаалаар орлогод авч, аймгийн ИТХ-ын 2025 оны 58 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 15,307.8 мянган төгрөгийн хөрөнгийг 12,790.0 мянган төгрөгөөр шинэчлэн үнэлж бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын явцад санхүүгийн тайланд хамгийн их ач холбогдолтой, аудитын явцад онцгой анхаарал шаардсан, материаллаг буруу

D:\Бичиг хэрэг\2026\Явсан бичиг\A4 тоот.docx

2226050048

илэрхийллийн өндөр эрсдэлтэй асуудал илрээгүй тул аудитын гол асуудал тодорхойлоогүй болно.

Бусад асуудал

Аудиторын дүгнэлтэд өөрчлөлт оруулахгүйгээр мэдээлэхэд, тус аудитын хүрээнд санхүүгийн тайланд хавсаргасан үйл ажиллагааны тайлан, статистик мэдээлэлд аудитын баталгаа өгөөгүй бөгөөд эдгээр нь аудитын дүгнэлтийн хамрах хүрээнд хамаарахгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	238,210,739.54	56,404,062.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	191,348,267.03	32,915,910.03
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	191,348,267.03	32,915,910.03
31211	Төрийн сангийн харилцах	191,348,267.03	32,915,910.03
33	АВЛАГА	-	100,000.00
33500	Бусад авлага	-	100,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	-	100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	46,862,472.51	23,388,152.51
35100	Түүхий эд материал	121,000.00	-
35110	Тусгай зориулалттай материал	121,000.00	-
35400	Хангамжийн материал	46,741,472.51	23,388,152.51
35410	Бичиг хэргийн материал	337,400.00	274,600.00
35420	Аж ахуйн материал	35,270,072.51	17,959,572.51
35440	Түлш, шатах тослох материал	3,441,000.00	2,668,380.00
35460	Хүнсний материал	3,633,000.00	2,485,600.00
35600	Мал амьтад	4,060,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	313,041,291.39	364,531,377.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	313,041,291.39	364,531,377.20
39200	Биет хөрөнгө	306,037,291.39	357,827,377.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	317,312,522.00	317,012,522.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(58,064,908.81)	(66,505,111.45)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	58,612,250.00	64,702,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,118,449.06)	(33,626,228.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,740,526.00	80,268,970.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,944,648.66)	(21,272,106.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,650,000.00	19,715,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,150,000.08)	(2,467,667.44)
393	Биет бус хөрөнгө	7,004,000.00	6,704,000.00
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(700,000.00)	(1,000,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,204,000.00	6,204,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	551,252,030.93	420,935,439.74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	1,944,550.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,944,550.00
41360	Бусад өглөг	-	1,944,550.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,356,550.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	588,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	551,252,030.93	418,990,889.74
51	Засгийн газрын хувь оролцоо	551,252,030.93	418,990,889.74
51100	Засгийн газрын оруулсан капитал	97,596,880.00	97,596,880.00
511002	Засгийн газрын оруулсан капитал орон нутгийн сан	97,596,880.00	97,596,880.00
512	Хуримтлагдсан үр дүн	383,891,884.51	251,630,743.32
51210	Өмнөх үеийн үр дүн	276,303,595.31	383,891,884.51
51220	Тайлант үеийн үр дүн	107,588,289.20	(132,261,141.19)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	69,763,266.42	69,763,266.42
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	551,252,030.93	420,935,439.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	1,169,908,500.00	1,144,913,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,114,400.00	82,775,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	28,114,400.00	82,775,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	610,000.00	2,360,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	610,000.00	2,360,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	26,602,200.00	80,415,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	902,200.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,141,794,100.00	1,062,138,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,086,679,100.00	1,006,135,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,086,679,100.00	1,006,135,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,115,000.00	56,002,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутаг/	55,115,000.00	56,002,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,062,320,210.80	1,277,174,441.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,062,320,210.80	1,277,174,441.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,062,317,464.19	1,276,002,904.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	745,464,350.00	904,794,566.00
210101	Үндсэн цалин	509,306,552.00	550,242,440.00
210102	Нэмэгдэл	216,501,858.00	298,260,748.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	29,239,984.00
210104	Урамшуулал	19,655,940.00	27,051,394.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,471,338.65	112,085,391.00
210201	Тэтгэврийн даатгал	63,068,945.65	75,404,246.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,230,037.00	9,172,268.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,619,619.00	4,589,935.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,445,056.00	4,587,937.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,107,681.00	18,331,005.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,200,163.39	45,603,883.50
210301	Гэрэл, цахилгаан	5,045,363.39	10,364,755.50
210302	Түлш, халаалт	31,973,800.00	33,903,128.00
210303	Цэвэр, бохир ус	1,181,000.00	1,336,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,944,000.00	25,519,300.00
210408	Бараа материал ақталсны зардал	8944000	25,519,300.00
2105	Нормативт зардал	99,857,620.00	104,611,080.00
210502	Хоол, хүнс	99857620	104,611,080.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,512,920.00	12,556,900.00
210604	Урсгал засвар	12,512,920.00	12,556,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,493,000.00	3,477,050.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,493,000.00	3,477,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,374,072.15	67,354,734.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,084,320.00	25,781,230.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,555,000.00	7,813,720.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,734,752.15	33,759,784.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,746.61	1,171,536.50
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,746.61	1,171,536.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,746.61	1,171,536.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	107,588,289.20	(132,261,141.19)
6	НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(4)-(5)	107,588,289.20	(132,261,141.19)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,142,404,100.00	1,064,498,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	610,000.00	2,360,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	610,000.00	2,360,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	610,000.00	2,360,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,141,794,100.00	1,062,138,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,086,679,100.00	1,006,135,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,086,679,100.00	1,006,135,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	55,115,000.00	56,002,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутаг/	55,115,000.00	56,002,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,032,573,577.53	1,218,095,787.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,032,573,577.53	1,218,095,787.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,032,570,830.92	1,216,924,250.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	745,131,868.88	904,894,566.00
210101	Үндсэн цалин	508,974,070.88	550,342,440.00
210102	Нэмэгдэл	216,501,858.00	298,260,748.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	29,239,984.00
210104	Урамшуулал	19,655,940.00	27,051,394.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,471,338.65	112,085,391.00
210201	Тэтгэврийн даатгал	63,068,945.65	75,404,246.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,230,037.00	9,172,268.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,619,619.00	4,589,935.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,445,056.00	4,587,937.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,107,681.00	18,331,005.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,177,333.39	44,831,263.50
210301	Гэрэл, цахилгаан	5,045,363.39	10,364,755.50
210302	Түлш, халаалт	38,950,970.00	33,130,508.00
210303	Цэвэр, бохир ус	1,181,000.00	1,336,000.00
2105	Нормативт зардал	105,604,370.00	103,463,680.00
210502	Хоол, хүнс	105,604,370.00	103,463,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,934,920.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	9,934,920.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,061,600.00	2,915,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,061,600.00	2,915,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,189,400.00	38,733,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,299,000.00	30,339,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,890,400.00	8,393,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,746.61	1,171,536.50
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,746.61	1,171,536.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,746.61	1,171,536.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	109,830,522.47	(153,597,487.00)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	5,089,000.00	4,834,870.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,089,000.00	4,834,870.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,089,000.00	4,834,870.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,089,000.00	4,834,870.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,089,000.00)	(4,834,870.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	104,741,522.47	(158,432,357.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	86,606,744.56	191,348,267.03
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	191,348,267.03	32,915,910.03

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	276,303,595.31	443,663,741.73
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	276,303,595.31	443,663,741.73
9	Тайлант үеийн үр дүн	-	-	107,588,289.20	107,588,289.20
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	383,891,884.51	551,252,030.93
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	383,891,884.51	551,252,030.93
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	383,891,884.51	551,252,030.93
19	Тайлант үеийн үр дүн	-	-	132,261,141.19	132,261,141.19
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	97,596,880.00	69,763,266.42	251,630,743.32	418,990,889.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,254,334,300.00	1,221,724,120.50	32,610,179.50	97.40
1	УРСГАЛ ЗАРДАЛ	1,254,334,300.00	1,221,724,120.50	32,610,179.50	97.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,254,334,300.00	1,221,724,120.50	32,610,179.50	97.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	920,080,200.00	904,894,566.00	15,185,634.00	98.35
210101	Үндсэн цалин	586,040,900.00	550,342,440.00	35,698,460.00	93.91
210102	Нэмэгдэл	316,219,300.00	298,260,748.00	17,958,552.00	94.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	29,239,984.00	(29,239,984.00)	-
210104	Урамшуулал	17,820,000.00	27,051,394.00	(9,231,394.00)	151.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,459,100.00	112,085,391.00	2,373,709.00	97.93
210201	Тэтгэврийн даатгал	77,655,900.00	75,404,246.00	2,251,654.00	97.10
210202	Тэтгэмжийн даатгал	9,200,800.00	9,172,268.00	28,532.00	99.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,600,400.00	4,589,935.00	10,465.00	99.77
210204	Ажилгүйдлийн даатгал	4,600,400.00	4,587,937.00	12,463.00	99.73
210205	Эрүүл мэндийн даатгал	18,401,600.00	18,331,005.00	70,595.00	99.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,252,800.00	44,831,263.50	8,421,536.50	84.19
210301	Гэрэл, цахилгаан	11,252,800.00	10,364,755.50	888,044.50	92.11
210302	Түлш, халаалт	38,000,000.00	33,130,508.00	4,869,492.00	87.19
210303	Цэвэр, бохир ус	4,000,000.00	1,336,000.00	2,664,000.00	33.40
2105	Нормативт зардал	110,087,200.00	103,463,680.00	6,623,520.00	93.98
210502	Хоол, хүнс	110,087,200.00	103,463,680.00	6,623,520.00	93.98
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,905,500.00	4,905,500.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,905,500.00	4,905,500.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,549,500.00	41,543,720.00	5,780.00	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,155,600.00	33,149,820.00	5,780.00	99.98
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	8,393,900.00	8,393,900.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,010,092,500.00	1,006,135,500.00	3,957,000.00	99.61
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,010,092,500.00	1,006,135,500.00	3,957,000.00	99.61
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,252,800.00	54,831,263.50	8,421,536.50	86.69
120010	Төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны хүрээнд хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,325,000.00	2,325,000.00	-	100.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	191,348,267.03	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	32,915,910.03	-	-

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант оны эцэст 3 байгууллага, 2 иргэнд 1,944.5 мянган төгрөгийн өглөгтэй, 1 ажилтанаас 100.0 мянган төгрөгийн авлагатай гарсан	1	2,044.5	-	-	-	-	1	2,044.5	-	-	-	-
Дүн	1	2,044.5	-	-	-	-	1	2,044.5	-	-	-	-